

УЛСЫН СҮЛЖЭЭНИЙ ГАЗРЫН УС СУДЛАЛЫН АЖИГЛАЛТЫН УЛСЫН СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
Т.УЯНГЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт -ийн хувь
1	2	3	4	5	6	7	8
Зорилт 1. “Ус судлалын Улсын сүлжээний шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ” зорилтын хүрээнд:							
1	Арга хэмжээ 1.1 Ус судлалын 17 автомат станцыг ажиллагаанд оруулах	Автомат станц суурилуулсан харуулын тоо	0	17	Ус судлалын 17 автомат багажийг нийслэл, 9 аймгийн 17 байршилд суурилуулах хуваарийг батлуулж, суурилуулахад шаардлагатай төсвийг ОНТХөрөнгөөр санхүүжүүлэхээр Засаг дарга нарт 01/527 дугаартай албан бичгийг хүргүүлсэн. Улаанбаатар хотын Туул, Сэлбэ гол, Завхан, Хөвсгөл, Баянхонгор аймгуудын, Түйн, Богд, Дэлгэрмөрөн голуудын 5 автомат багажийн хэмжилтийн мэдээг мэдээллийн нэгдсэн системд дамжуулж, ажиглагчийн хэмжилттэй харьцуулан, тохируулгыг хийж ажилласан. Энэхүү төхөөрөмжийг суурилуулсны үр дүнд голын усны түвшин болон урсцыг 5 минут тутамд хэмжих мөн үерийн эрсдэлийг шуурхай тооцоолох боломжтой болсон. Тус төхөөрөмж нь өвлийн улиралд ажиллах боломжгүй тул	05.01-12.01	100% 80 ✓

					17 автомат багажийг мөсний үзэгдэл эхэлснээр хураан, ирэх оны 4 дүгээр сараас эхлэн дахин суурилуулан хэмжилтийг үргэлжлүүлэн хийж ажиллана.		
2	Арга хэмжээ 1.2 Ус судлалын улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	Нэн шаардлагатай хэмжих хэрэгслээр хангасан байдал	Батлагдсан хөтөлбөрийн дагуу	Багаж хувцас хэрэглэлээр хангагдсан байна.	Ус судлалын улсын сүлжээний хөтөлбөрийг хэрэгжилтийг сайжруулахын тулд 16 аймгийн 154 харуулд нэн шаардлагатай багаж, хувцас хэрэглэлийн судалгааг гаргаж, худалдан авах ажиллагаанд 16 нэр төрлийн багаж, хэрэгслийн техникийн тодорхойлолтыг гаргаж өгсөн. Худалдан авах ажиллагааг 04 дүгээр сарын 17 өдөр нээхэд тендерийн материал ирээгүй, 08 сарын 04-ны өдөр, 09 дүгээр сарын 09-ний өдрүүдэд нээхэд "Ата юрду" ХХК, "Азей" ХХК тендерийн материал ирүүлсэн боловч "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай" хуульд заасан шаардлагуудыг хангаагүй болно. Иймд зардлыг төсвийн хэмнэлтэд тооцож, хураагдсан болно. Хамтын ажиллагааны хүрээнд Усны газарт 2025 оны давсан орлогоос нь ус судлалын улсын сүлжээний албан хаагчдад нэн шаардлагатай 210.150.000 төгрөгийн үнэ бүхий 5 төрлийн хувцас хэрэглэлээр хангахад дэмжлэг үзүүлэн хамтарч ажиллах тухай 1/152 дугаартай албан бичгийг 11 сарын 17-ны өдөр хүргүүлсэн.	04.17-12.31	100%
3	Арга хэмжээ 1.3 Ус судлалын улсын сүлжээний	Газрын даргаар	Тухай бүрд	Нэгжийг буулгах, шилжүүлэх	2025 онд ус судлалын улсын сүлжээний нэгжийг шилжүүлэн ажиллах тухай хүсэлт Хөвсгөл аймгийн УЦУОШТ-өөс 69	05.01-12.31	100%

*Хамтын
хийг үрж
сөх мөжрөх
80с.*

80

✓

	нэгжийг байгуулах, татан буулгах, шилжүүлэхэд мэргэжлийн дүгнэлт гарган шийдвэрлүүлэх	батлуулсан байна		тухай дүгнэлтийг гарган танилцуулан газрын даргаар батлуулсан байна	дугаартай албан бичгээр ирсэн. Хүсэлтийн дагуу судлан үзэж Бүгсий голын голидролын өөрчлөлт, сүүлийн жилийн хур тунадасны өөрчлөлтөөс хамааран тухайн гол салаалан урсаж эхэлсэн. Иймд ус судлалын гормын хэмжилтүүд нарийвчлалтай үнэн бодит гарах боломжгүй тул Бүгсий-Төмөрбулаг ус судлалын харуулыг шилжүүлэн байршуулах боломжит байршлыг тодорхойлох арга зүйн зөвлөгөө өгч, судлуулан, боломжит байршлыг тодорхойлон, газрын даргын 2025 оны 09 сарын 24-ны өдрийн А/200 дугаартай тушаалаар шинээр байрших солбилцолыг тусган, харуулын байрыг нүүлгэн шилжүүлсэн. Шинэ байршлын солбилцолыг мэдээллийн санд нэмж, шинэчилсэн.		
4	Арга хэмжээ 1.4 Ус судлалын улсын сүлжээний шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор төсөл боловсруулан төсөл хөтөлбөрт санал өгөх	1	0	1	Ус судлалын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор гадаргын усны түвшин, урсцын хурд, өнгөрөлтийг хэмжих арга зүй, загварчлалын арга сэдэвт чадавхжуулах сургалтын төслийг 5 арга хэмжээтэйгээр боловсруулан, Сангийн яамнаас хамтын ажиллагааны хүрээнд зарласан Солонгос улсын Санхүү эдийн засгийн яамны KSP төслийн сонгон шалгаруулалтад 10 дугаар сарын 27-ны өдрийн 01/772 дугаар албан бичгээр баталгаажуулан саналаа хүргүүлсэн. Төслийн сонгон шалгаруулалтын хариу гараагүй байгаа болно.	06.02-12.01	100%
5	Арга хэмжээ 1.5 Ус судлалын	10	17	27	Ус судлалын 10 автомат станцыг худалдан авах 1.0 тэрбум төгрөгийн зардлыг БОУАӨ-ийн Сайдын багцаас	04.17-12.31	100%

	автомат станцын сүлжээг өргөтгөх				шийдвэрлүүлж, техникийн тодорхойлолт болон холбогдох материалыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлсэн. Тус газраас 02 дугаар сарын 17-ны өдөр тендер зарлан, 04 дүгээр сарын 25-ний өдөр нээлтийг хийж гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан боловч Төрийн хэмнэлтийн хуулийн дагуу 05 дугаар сарын 31-ны дотор худалдан авах ажиллагааг зохион байгуулж дуусаагүй тул холбогдох зардлыг төсвийн хэмнэлтэд тооцож, хураагдсан.		
6	Арга хэмжээ 1.6 Ус судлалын улсын сүлжээний ажиглалтын хөтөлбөрт өөрчлөлтийг оруулж, шинэчилсэн төслийг боловсруулах	Хөтөлбөрийг боловсруулсан байна	БОНХАЖС -ын 2016 оны А/02 тушаалаар батлагдсан.	Хөтөлбөрийг боловсруулж ажлын хэсгийн ахлахад өгсөн байна	Ус судлалын улсын сүлжээний ажиглалтын хөтөлбөрийг боловсруулахад дараах арга хэмжээг хэрэгжүүлэн боловсруулсан. Ус судлалын 147 харуулын нэршил, хэмжилтийн цэгийн солбилцолыг шинэчлэн тодорхойлсон. Ус судлалын улсын сүлжээний ажиглалтын хөтөлбөрт шаардлагатай хэмжилтийг тодорхойлж, хяналт шинжилгээний чиглэлээр усны горимын 17 хэмжилт, газрын доор усны 5 хэмжилт, мөстөл судлалын 7 хэмжилт, мөн мэдээ дамжуулалт 5 төрөл, үйлчилгээний ажлын хөтөлбөр 7 төрлөөр мэдээ мэдээллийг гаргахаар хөтөлбөрт тусган өгч, боловсруулан ажилласан. Боловсруулсан хөтөлбөрийг ажлын хэсгийн ахлахад цахимаар хүргүүлсэн.	11.17-12.31	100% 90
Зорилт 2. “Ус судлалын ажиглалт, хэмжлийн технологийн мөрдөлтөд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах, орон нутгийн ус судлалын салбарын ажлыг дүгнэх, албан хаагчдыг чадваржуулах” зорилтын хүрээнд							

1	<p>Арга хэмжээ 2.1 Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын зааврыг шинэчлэн, ус судлалын инженер, техникч, харуулуудыг мэдээллээр ханган ажиллах</p>	Нэмэлт өөрчлөлт оруулсан байх	2010 онд хэвлэгдэн гарсан.	Автомат түвшин хэмжигч багажийн ажиллах зааврыг орчуулан, цахим хэлбэр заавар үүсгэсэн байна.	Автомат түвшин хэмжигч багажийн хэмжлийн зааврыг Англи хэлнээс Монгол хэлрүү орчуулан цахим гарын авлага болгохоор орчуулгын ажлыг хийсэн. Одоогоор тус автомат түвшин хэмжигч нь 147 харуулын 17 харуул дээр ашиглагдаж байгаа тул цаасан хэлбэрээр гаргахгүй болно.	06.02-12.31	100% 80
2	<p>Арга хэмжээ 2.2 Орон нутгийн ус судлалын албан хаагчдыг чадваржуулах, мэдээлэл болон мэргэжил арга зүйгээр хангах</p>	2 доошгүй удаа	Тухай бүрд	2 доошгүй удаа сургалт, мэдээ мэдээллээр хангасан байна.	<p>Орон нутгийн ус судлалын албан хаагч нарын хүрээнд 2 удаагийн сургалт, мэдээ мэдээллийг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>1. 8 дугаар сарын 21-22-ны өдрүүдэд ЦУОШГ-ын даргаар батлагдсан хөтөлбөрийн дагуу нийлүүлэгч компанитай хамтран RQ-30 автомат багажийн танилцуулга, Сэлбэ-Дамбадаржаа харуулыг автомат багажаар тоноглон суурилуулах үйл явц, программыг ашиглах тухай заавар зөвлөгөө мэдээллийг нийслэл, аймгуудын усны инженер, техникч нарт танилцуулсан. Цаашид өөрсдийн аймагт багажийг зөв, зохистой суурилуулахад анхаарах зөвлөмж, зааврыг өгч ажилласан.</p> <p>2. АНУ-ын Мэдисон дахь Висконсины их сургуулийн судлаач Уильям Стракатай хамтран 10 дугаар сарын 6-ны өдөр "NOAA цуврал хиймэл дагуулын үерийн бүтээгдэхүүн" сэдэвт сургалтыг цахим болон Монгол орчуулгатайгаар орон нутгийн инженер, техникч нарийг хамруулан зохион байгуулсан. Энэхүү</p>	06.02-12.01	100%

					<p>сургалтаар ус судлалын албан хаагч нар хиймэл дагуулын мэдээллийг ашиглах, тандан судалгаа болон үерийн мэдээлэлтэй холбох дэвшилтэд технологийн хослуулан судалгаа, шинжилгээний ажлыг илүү өргөн цар хүрээтэй болгох тухай мэдээлэлтэй болсон.</p> <p>2025 онд ус судлалын улсын сүлжээний хөтөлбөрт ажлыг тасалдуулахгүйгээр ажиглагч нарын ээлжийн амралтыг зохицуулах, автомат түвшин хэмжигчийг суурилуулах, хэмжилтэд хяналт тавих зэрэг 50 гаруй удаагийн мэргэжил арга зүйн зөвлөгөөг утас болон нүүр номын чатаар өгч ажилласан.</p>		
3	<p>Арга хэмжээ 2.3 Ус судлалын улсын сүлжээний 2026 онд шаардлагатай дэвтэр, хүснэгтийн захиалгыг зөв, чанартай хэвлүүлэхэд хяналт тавьж, хамтран ажиллах, хүлээн авах, хуваарилах</p>	<p>Дэвтэр хүснэгтийг захиалгад хяналт тавьж, хүлээн аван, хуваарилсан байна</p>	-	<p>Дэвтэр хүснэгтийг хүлээн аван, хуваарилсан байна.</p>	<p>2026 онд шаардлагатай Ус судлалын улсын сүлжээний 16 төвийн 147 харуулын хэмжлийн 8 төрлийн дэвтэр, хүснэгтийн судалгааг авч нэгтгэн, захиалгыг өгч, захиалгыг зөв хэвлүүлэхэд хяналт тавин ажилласан. Захиалгын дагуу 8 төрлийн 10210 ширхэг дэвтэр хүснэгтийг хүлээн авч, хуваарилалтын дагуу орон нутгуудад хүлээлгэн өгсөн.</p>	10-12.31	100%
Зорилт 3. “Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах” зорилтын хүрээнд							
1	<p>Арга хэмжээ 3.1 Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн</p>	<p>Төлөвлөгөөний гүйцэтгэлийн үнэлгээ</p>	-	Хангалттай	<p>Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг нийт 14 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулсан. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний</p>	04.17-12.31	100%

	төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж ажлын гүйцэтгэлийг тайлагнан үр дүнгээ үнэлүүлэх				хагаж жилийн тайланг газрын ХДАХ-ээр хянуулан хангалттай буюу 85% дүнгийн үнэлгээтэйгээр үнэлэгдсэн.		
2	Арга хэмжээ 3.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг мөрдөн ажиллах	Ашиг сонирхлын болон ёс зүйн зөрчил гаргасан эсэх /тийм, үгүй/	-	Үгүй	Төрийн албан хаагчийн ёс зүйн хууль, байгууллагын дотоод журмыг даган мөрдөн ажиллаж байна. Мөн Авлигын тухай хуулийн дагуу ХАСХОМ-ыг хуулийн хугацаад нь гарган, эрх бүхий албан тушаалтад баталгаажуулах хуудсыг хүлээлгэн өгсөн. 2025 оны 12 дугаар сарын 09-ны өдөр авлигын эсрэг олон улсын өдрийг энэ жил "Авлигын эсрэг залуустай хамт нэгдье" уриан дор газрын албан хаагчтай нартай нэгдэн тэмдэглэсэн.	04.17-12.31	100%
3	Арга хэмжээ 3.3 Удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг хэрэгжүүлж ажиллах	Үүрэг даалгаврын хэрэгжилтийн хувь	-	100%	- Газрын даргын 2023 оны А/78 дугаар тушаалаар батлагдсан дагуу Арга зүйн зөвлөлийн ээлжит хурал 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр Уур амьсгалын өөрчлөлт, нөөцийн судалгааны хэлтсээс боловсруулан гаргаж буй цаг уурын ажиглалтын цахим ЦД-1 дэвтрийг үйлдвэрлэлд нэтрүүлэх эсэх талаар арга зүйн зөвлөлийн хуралд оролцож, санал өгч ажилсан. - Газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 09 өдрийн А/218 дугаар тушаалаар Ус цаг уур орчны шинжилгээний ажлын аюулгүй ажиллагааны нэгдсэн заавар боловсруулах ажлын хэсэгт ажиллан,	04.17-12.31	100%

					<p>зааврыг боловсруулан, ажлын хэсгийн даргад хүргүүлсэн.</p> <p>- Дэлхийн цаг уурын байгууллагаас гаргасан “Нислэгийн цаг уурын мэдээгээр хангах журам”-ын орчуулгыг шалгах ажлын хэсэгт орж ажиллаж байна. Энэхүү журмын WMO-No 11000 баримт бичгийн орчуулгыг шалгах ажлыг хийж гүйцэтгэсэн.</p> <p>- Дэлхийн цаг уурын байгууллагаас тус газарт үнэлгээ хийхээр ирсэн ажлын багт ус судлалын улсын сүлжээг танилцуулан, үнэлгээний 92 асуумжид хариулан, одоогийн ус судлалын салбарын мэдээллээр ханган ажилласан.</p> <p>- ШУТИС-ийн Хүрээлэн буй орчны танхимас “Усны шинжлэх ухаан ба инженерчлэл 2025” эрдэм шинжилгээний бага хуралд хамтран ажиллаж, эрдэм шинжилгээний өгүүлэлд шүүмжлэгчээр орж ажилласан.</p> <p>- ШУТИС-ийн Хүрээлэн буй орчны танхимын Усны менежмент, Усны барилга байгууламжийн 1-4 курсийн 54 оюутнуудад ЦУОШГ-ын танилцуулга, Ус судлалын улсын сүлжээний ажлын горим түүний хэмжилт болон судалгаа шинжилгээний үйл явцын талаарх мэдээллийг 2 удаагийн 3 цагийн лекцийг хүргэсэн. Энэхүү мэдээллийн үр дүнд усны чиглэлээр сурч байгаа оюутан залуус ЦУОШГ-ын ус судлалын салбарын усны хэмжилт болон түүнээс гарч байгаа судалгаа шинжилгээний мэдээлэлтэй болсон.</p>		
--	--	--	--	--	---	--	--

					- БОУАӨ Сайдын 2025 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/93 дугаар тушаалаар аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хөнгөлөлт эдлэх бүтээн байгуулалт, төсөл, үйл ажиллагаанд тавигдах шаардлага батлагдсан. Тус тушаалын хавсралтад ус судлалын 4 чиглэлээр нэмэлт өөрчлөлт оруулах тухай саналыг боловсруулан 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 01/642 дугаартай албан бичгээр БОУАӨ Сайдад хүргүүлэв.		
--	--	--	--	--	--	--	--


Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт:

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	Удирдлагын академийн Төрийн албаны мэрэгшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдах	1	0	Сургалтад хамрагдаж байх	Удирдлагын академийн Төрийн албаны мэрэгшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 10 дугаар сарын 27-ны өдрөөс 2026 оны 01 сарын 26 өдөр хүртэл 11 багц (танхимаар 8 багц, бие даан судлах 2 багц, төгсөлтийн шалгалт 1 багц) сургалтыг өөрийн төлбөрөөр суралцаж байна. 12 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 11 багц сургалтын 8 багц сургалтын шалгалтаа амжилттай өгч хаалгасан. - Ахисан түвшний Жендерийн дүн шинжилгээ цахим сургалтад хамрагдсан. Сертификат дугаар: №:756997 - Монгол бичгийн нийт 24 цагийн анхан, дунд болон ахисан шатны цахим сургалтад хамрагдсан.	10.27-01.26	100%

					Сертификат дугаар: анхан шат: № 755487 Дунд шат: № 756999 Ахисан шат: № 757001		
2.	Төрийн албаны зөвлөл, төсөл хөтөлбөрөөс зохион байгуулж буй сургалтад тухай бүр нь хамрагдсан байх.	Сургалтад хамрагдсан байна	Жил бүр төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж байгаа сургалтад хамрагддаг	2 доошгүй сургалтад хамрагдсан байх	2025 онд нийт 5 удаагийн сургалт, мэдээ мэдээлэлд хамрагдсан байна. 1. Газраас зохион байгуулсан Авлигын тухай хууль, түүнээс сэргийлэх тухай мэдээ мэдээллийн сургалтад хамрагдсан 2. 05 дугаар сарын 28-ны өдөр Гүйцэтгэлийн хэмжилтийн талбар сэдэвт онлайн сургалтад хамрагдсан. Сертификат дугаар: А5331 3. ГЗБГЗЗЕГ, Төв Азийн хөрс судлалын нэгдсэн холбоо хамтран 10 дугаар сарын 15-ны өдрөөс 11 дүгээр сарын 13-ны өдрийг хүртэл 8 удаагийн Хөрсний экологийн чадавхыг үнэлэх, хөрс, ургамлын ангиллалын стандартыг олон улсын стандартад нийүүлэх сургалтад хамрагдсан. 4. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн АЗ сургалтад өөрийн зардлаар суралцаж байна. 5. Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамнаас “Үерийн эрсдэлийн үнэлгээ, шаардагдах өгөгдөл, мэдээлэл” сэдэвт сургалтад 6 дугаар сарын 19-20-ны өдрүүдэд 2 өдрийн мэдээ мэдээлэл сургалтад хамрагдсан.	04.17-12.31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Мэргэжилтэн
(Албан тушаал)

Т.Уянга / 
(Нэр, гарын үсэг)

2025 оны 12 сарын 10
(Огноо)

УС СУДЛАЛЫН АЖИГЛАЛТЫН УЛСЫН СҮЛЖЭЭ ХАРИУЦСАН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН
ТӨМӨРТОГООГИЙН УЯНГЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Цаг уур, орчны шинжилгээний газар
Нэгжийн нэр: Улсын сүлжээ газар

1. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Ус судлалын Улсын сүлжээний шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, бүрэн хэрэгжүүлэх арга хэмжээ"-г хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 1.1 Ус судлалын 17 автомат станцыг ажиллагаанд оруулах	60 48	10	70 58	58
2.	Арга хэмжээ 1.2 Ус судлалын улсын сүлжээний хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	60 48	10	70 58	58
3.	Арга хэмжээ 1.3 Ус судлалын улсын сүлжээний нэгжийг байгуулах, татан буулгах, шилжүүлэхэд мэргэжлийн дүгнэлт гарган шийдвэрлүүлэх	60	10	70	70
4	Арга хэмжээ 1.4 Ус судлалын улсын сүлжээний шинжилгээ, мэдээлэл, үйлчилгээний ажлын хөтөлбөрийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор төсөл боловсруулан төсөл хөтөлбөрт санал өгөх	60	10	70	70
5	Арга хэмжээ 1.5 Ус судлалын автомат станцын сүлжээг өргөтгөх	60	10	70	70

6	Арга хэмжээ 1.6 Ус судлалын улсын сүлжээний ажиглалтын хөтөлбөрт өөрчлөлтийг оруулж, шинэчилсэн төслийг боловсруулах	60 59	10	70 64	64
Зорилт 2. "Ус судлалын ажиглалт, хэмжлийн технологийн мөрдөлтөд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангах, орон нутгийн ус судлалын салбарын ажлыг дүгнэх, албан хаагчдыг чадваржуулах" чиг үүргийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 2.1 Ус, цаг уур, орчны шинжилгээний ажлын зааврыг шинэчлэн, ус судлалын инженер, техникч, харуулуудыг мэдээллээр ханган ажиллах	60 48	10	70 58	58
2.	Арга хэмжээ 2.2 Орон нутгийн ус судлалын албан хаагчдыг чадваржуулах, мэдээлэл болон мэргэжил арга зүйгээр хангах	60 59	10	70 64	64
3.	Арга хэмжээ 2.3 Ус судлалын улсын сүлжээний 2026 онд шаардлагатай дэвтэр, хүснэгтийн захиалгыг зөв, чанартай хэвлүүлэхэд хяналт тавьж, хамтран ажиллах, хүлээн авах, хуваарилах	60	10	70	70
Зорилт 3. "Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах" зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Арга хэмжээ 3.1 Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж ажлын гүйцэтгэлийг тайлагнан үр дүнгээ үнэлүүлэх	60	10	70	70
2.	Арга хэмжээ 3.2 Төрийн албан хаагчийн ёс зүйн хуулийг мөрдөн ажиллах	60	10	70	70
3.	Арга хэмжээ 3.3 Удирдлагаас хуулийн хүрээнд өгсөн үүрэг даалгавар, цаг үеийн ажлыг хэрэгжүүлж ажиллах	60	10	70	70
Дундаж оноо:				70	66

66

2. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийн хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
				1
1.	Удирдлагын академийн Төрийн албаны мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад хамрагдах			15
2.	Мэдлэг, ур чадвараа сайжруулахаар мэдээ мэдээлэл, сургалтад хамрагдсан байх			
Дундаж оноо				15

3. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7 оноо)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
			1
1.	Хандлага, ёс зүй		
2.	Дүн шинжилгээ хийх		
3.	Асуудал шийдвэрлэх		
4.	Хариуцлагатай байдал		
5.	Ажлын цаг ашиглалт		
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6.	Мэргэжлийн ур чадвар 1.		
7.	Мэргэжлийн ур чадвар 2.		
8.	Мэргэжлийн ур чадвар 3.		
Дундаж оноо			

4. Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)

Д/д	Үзүүлэлт	Хамт олны үнэлгээ (0-8 оноо)
		1
1.	Хандлага, ёс зүй	
2.	Багаар ажиллах	
3.	Харилцаа	
Дундаж оноо		

5. Гүйцэтгэлийн үнэлгээ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно.)	(70 хүртэлх оноо) 6.0
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	(15 хүртэлх оноо) 15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	(7 хүртэлх оноо) 6.8

4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	(8 хүртэлх оноо) 8
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	(..... оноо)
Нийт оноо = (Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		95,8

Үнэлгээ өгсөн:

Нэгжийн дарга

Улсын сүлжээний газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Д.Уламбаяр/
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

**Үнэлгээтэй танилцаж,
зөвшөөрсөн:**

Төрийн жинхэнэ албан хаагч:

Ус судлалын ажиглалтын улсын
сүлжээ хариуцсан ахлах мэргэжилтэн
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Г.Уянга/
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

Үнэлгээг хянасан:

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Хяналт, дотоод аудитын хэлтсийн дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Х.Оюунбилэг/
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн асуудал хариуцсан
ахлах мэргэжилтэн
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Ж.Энхчимэг/
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

Үнэлгээг баталгаажуулсан:

Төсвийн шууд захирагч

Цаг уур, орчны шинжилгээний
газрын дарга
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Э.Баттулга/
(албан хаагчийн нэр)

.....
(огноо)

